

**Шинээр болон дахин сэргэх хандлагатай
байгаа халдварт өвчнүүд, түүнтэй тэмцэх
сэргийлэх арга хэмжээ**



Шинэ өвчнүүд оношлогдох болсон шалтгаан

- Бичил биетний хувьсал, хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдлын алдагдал, уур амьсгалын өөрчлөлт, хүн, мал, амьтны амьдралын хэв маяг, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шинэ шинэ өвчнүүд манай дэлхий дээр болон тодорхой бүс нутагт гарах болов.
- Тухайлбал, сүүлийн 30-аад жилд хүн мал амьтанд халдварт өвчин үүсгэдэг 90 гаруй бичил биетэн тодорхойлогдсоны 50 % нь урьд мэдэгдэж байгаагүй шинэ халдварууд байгаагийн дотор мөн 50-иад хувь нь зоонозын халдварт өвчин болох нь тогтоогдоод байна.
- Оношлох чадавхи сайжирсан
- Эдгээрээс манай улсад доорхи өвчнүүд шинээр илрээд байна. Үүнд:

Шинээр оношлогдож буй өвчнүүд

- Хонь, ямааны уушигны аденоматоз
- Хонь, ямааны маеди-висна
- Хэл хөхрөх
- Баруун Нилийн халуурал
- Гахайн үржил-амьсгалын замын хам шинж
- Хачигт борреллэз (Лаймын өвчин)
- Хачигт энцефалит
- Шувууны томуу
- Ньюкаслийн өвчин
- Үхрийн уушигны синсициал вирусийн халдвар
- Адууны үений халдварт үрэвсэл гэх мэт

Дахин сэргэж буй өвчнүүд

- Шүлхий (1974, 2000, 2001, 2004, 2010, 2013)
- Хонины цэцэг (1977, 2006)
- Ямааны цэцэг (1967, 2008)
- Томуу (1974, 1984, 1994, 2007, 2011. 2013)
- Гахайн сонгомол мялзан (1982, 2007)
- *Галзуу*
- *Боом*
- *Хонь, ямааны сохор догол*
- *Ишиг хурганы кокцидоз гэх мэт*

Манай оронд шинээр оношлогдож буй өвчнүүд

- Аденоматозоор өвчилсөн хонины хатууран цуллагжсан уушиг



- Хонины уушигний аденоматоз

Үүсгэгч: Retroviridae овгийн Betaretrovirus төрлийн аденоматозын вирусээр үүсгэгдэнэ.

Мэдрэмтгий амьтан: Хонь илүү мэдрэмтгий, ямаа өвчилсөн тохиолдол байдаг.

Тархалт: Европ, Африк, Ази, Америк тивд ихээхэн тархсан


Манай оронд: 2006 онд Төв аймгийн Лүн суманд анх оношлогдсон

Эмнэл зүй ь: Ханиах, турж эцэх, шингэн нус гоожих зэрэг

Халдвар дамжих зам нь: Амьсгалын замын төрөл бүрийн шүүрэл, түүгээр бохирдсон тэжээл, ус, билчээр

Хонь, ямааны маеди-висна өвчин

- Өвчилсөн хонины уушгинд гарсан эсгэг өөрчлөлт



- **Үүсгэгч:** Retroviridae овгийн Lentivirus төрлийн вирусээр үүсгэгддэг.

- **Мэдрэмтгий амьтан:** Хонь, ямаа, болон зарим хивэгч амьтад

- **Тархалт:** Авсрали, Шинэ Зеландаас бусад оронд нилээд тархалттай. Сүүлийн үед хүрээ нь тэлсээр байна.,

- **Манай оронд:** 2007 онд Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр, Түшиг, Зүүн брэн, Булган, Хөвсгөл, Төв аймгийн зарим сумдад тандалтаар эсрэг бием илрүүлсэн. Хонь, ямаа 9,2-14,6%-иар.

- **Эмнэл зүй:** Хэрэв онц хоруу чанартай л биш бол бараг илэрдэггүй

- **Халдвар дамжих зам:** Амьсгалын замын шүүрэл, гал уураг, сүү, баасаар гадгашлана


Хэл хөхрөх (Хөх хэлтэх)

- Хэл хөхөрч гадгаш бултайна




- **Үүсгэгч:** Reoviridae овгийн Orbivirus төрлийн вирусээр үүсгэгддэг.
- **Мэдрэмтгий амьтан:** Хонь, ямаа, үхэр, буга, нэг бөхт тэмээ болон хивэгч амьтад
- **Тархалт:** Антрактид тивээс бараг бүх тивд Сүүлийн үед хүрээ нь тэлсээр байна.
- **Манай оронд:** 2007-2008 онд ДХХААБ-аас хэрэгжүүлсэн төслөөр хийгдсэн тандан шинжилгээгээр ямааны 80%, хонины 50%, Төв лаб. Шинжилгээгээр үхэрт 5-7%, хонь 80%-д, ОХУ-д Завханы 70% илрүүлсэн
- **Эмнэл зүй:** Хэрэв онц хоруу чанартай л биш бол бараг илэрдэггүй
- **Халдвар дамжих зам:** Culicoides төрлийн цус сорогч ялаа буюу шумуул. Энэ нь 5000 гаруй зүйлтэй

Баруун Нилийн халдвар



- **Үүсгэгч:** Flaviviridae овгийн Flavivirus төрлийн арбовирус үүсгэдэг.
- **Мэдрэмтгий амьтан:** Шувууд түүний дотор Бор шувуутан, Шонхортон, Уйлтан багийн шувууд. Хөхтөнөөс адууны төрөл
- **Тархалт:** Африк, Азийн ихэнхи орон. Сүүлийн үед Европ, Газар дундын тэнгис, Ойрх Дорнод, Авсрали, Америк
- **Манай оронд:** 2004 онд анх БГХӨСҮТ-ийн судлаачид зарим шувуу, мэрэгчдэд эсрэг биом илрүүлсэн. Төв лабораторит бас адууны 24%, хонь, ямааны ийлдсэнд 7% Үхэрт 5%, -ийн эсрэг биом илрүүлсэн.
- **Эмнэл зүй:** Эмнэл зүй бараг илэрдэггүй
- **Халдвар дамжих зам:** Шумуул-шувуу-шумуул. Түүнд хазуулсан амьтад

Баруун нил вирус болон Япон энцефалитын тархалтын зураглал



Гахайн үржил-амьсгалын замын хам шинж


- Эд эрхтэнд үүссэн эмгэг хувирал



- **Үүсгэгч:** Arteriviridae овгийн Arterivirus үүсгэдэг
- **Мэдрэмтгий амьтан:** Зөвхөн гахай
- **Тархалт:** 1987 онд анх Хойт Америкт, 1990 оноос Европийн орнуудад, гарч одоо гахай аж ахуй эрхэлдэг ихэнхи оронд оношлогдоод байна.
- **Манай оронд:** 2007 онд Улаанбаатарт 3 аж ахуйд сэжиг 96,7%-д нь эсрэг бием илэрч байжээ. Булган аймагт, 2010 онд Дарханд хэд хэдэн өрхийн аж ахуйд эмнэл зүй илэрч оношлогдсон
- **Эмнэл зүй:** Төллөлт саатана. Амьсгалын эмгэг шинж илрэнэ
- **Халдвар дамжих зам:** Өвчтэй гахайн бүх шүүрлээр халдвар дамжина

Хачигт энцефалит ,түүний төрлийн энцефалитууд


- Хачигт энцефалитын тархалт, эзэн солилцоо



- **Үүсгэгч:** Flaviviridae овгийн Flavivirus төрлийн Арбовирус үүсгэдэг. 1937 онд анх үүсгэгчийг гарган авсан.
- **Мэдрэмтгий амьтан:** Мал, амьтдад бараг эмгэг илрэхгүй, харин хүн өвчилсөн тохиолдолд үхэлд хүргэнэ
- **Тархалт:** Энэ өвчин нь Ixodes хачигны тархалттай холбоотойгоор Хятадын хойт хэсэг, Японоос баруун тийш ОХУ-ын Алс дорнод, Цаашлаад Европод тархалттай
- **Манай оронд:** 2008-2009 онд Төв лабын тандалтаар Сэлэнгэ, Булган, Дорнод аймгаас авсан адуу, хонь, ямааны ийлдсэнд эсрэг бием илрүүлсэн
- **Эмнэл зүй:** Ихэвчлэн мэдрэлийн эмгэг үзүүлнэ
- **Халдвар дамжих:** Гол дамжих зам нь дээрхи зүйлийн хачиг.

Шувууны томуу Orthomyxovirus

- Шувууны томуугийн үед илрэх түгээмэл шинж тэмдэг ба үүсгэгчийн эргэлт



- **Үүсгэгч:** Myxoviridae овгийн төрлийн Influenza вирусээр үүсгэгддэг
- **Мэдрэмтгий амьтан:** Хүн, мал, амьтан, бараг бүх төрлийн шувууд
- **Таралт:** 2001 оноос хойш бараг бүх тивийн ихэнхи оронд оношлогдсон.
- **Манай оронд:** Анх 2005,2006 онд жил дараалан оношлогдсон. Дараа нь 2009 онд Архангайд 2 удаа, 2010 онд Сүхбаатар аймагт оношлогдсон
- **Эмнэл зүй:** Зэрлэг шувуудад голдуу мэдрэлийг эмгэг ажиглагдаж байгаа
- **Халдвар дамжих зам:** Нүүдлийн шувууд хамгийн эрсдэлтэй байна. Агаар дуслын замаар ихэвчлэн халдана

Ньюкаслийн өвчин

- Олноороо хорогдоно. Бас хэлбэргүй өндөг гарна



- **Үүсгэгч:** Paramyxoviridae овгийн Avulavirusийн төрлөөр үүсгэгддэг.
- **Мэдрэмтгий амьтан:** Ихэнхи төрлийн зэрлэг ба тэжээвэр шувууд
- **Тархалт:** Ази, Ойрх Дорнод, Африк, Төв ба Өмнөд Америкт ихээхэн тархалттай.
- **Манай оронд:** Хоруу чанар султай хэлбэрээр оношлогдож байсан. 2010-8-16-нд гэнэт УБ хотын ХУД-ийн “Нионишель” компаний аж ахуйд дэгдэж албан ёсоор оношлогдсон
- **Эмнэл зүй:** Омгийн хоруу чанараас хамаарч янз бүр байна.
- **Халдвар дамжих зам:** Халдвар авсан шувууны сангас, бусад халдвар авсан бүх материалаар дамжина

Хачигт борреллёз буюу Лаймын өвчин

- Хачигт хазуулснаас үүсэх эмгэг



- **Үүсгэгч:** Мушгиа хэлбэрийн Borolia burgdorferi нянгаар үүсгэгддэг. Анх 1975 онд АНУ-ын Лайм хотын хүүхдүүдэд илэрсэн боловч үүсгэгчийг нь 1981 онд Нью-Йоркод Ixodes dammini зүйлийн хачигаас гарган авсан
- **Мэдрэмтгий амьтан:** Адуу, үхэр, нохой хамгийн их өртөмтгий
- **Тархалт:** Хойт Америк, Европ, ОХУ, Хятад, Япон, Австралид их тархсан
- **Манай оронд:** 2009 онд явуулсан тандалтаар Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Дорнод, А/х, Ө/х Булганаас авсан хүний ийлдсэнд эсрэг бием илэрсэн
- **Эмнэл зүй:** Өвчлөмтгий амьтан бүрт янз бүр тул оношлоход хэцүү
- **Дамжуулагч:** Хачиг болон түүнээс халдвар авсан мэрэгчид

Дахин сэргэж буй өвчнүүд. Шүлхий

- Голлох эмгэг хувиралтууд



- **Үүсгэгч.** Picornaviridae овгийн Aphthovirus төрөлд хамаарах O, A, C, SAT-1, 2, 3, гэсэн 7 хэвшлээр үүснэ
- **Мэдрэмтгий амьтан нь:** Бүх төрлийн салаа туурайтан
- **Тархалт:** 19-р зууны эцэс хүртэл бүх дэлхийд өргөн тархсан өвчин байлаа. Одоо Ази, Африк, Ойрх Дорнод, Өмнөт Америкт оргономол хэлбэртэй байна.
- **Манай оронд:** 1974 оноос гараагүй боловч 2000 оноос дахин сэргэж 2001, 2002, 2004 2005, 2006, 2010, 2013 онуудад
- **Эмнэл зүй:** Амьтны төрлөөс хамаарч янз бүр боловч, үхэрт илт ажиглагдана
- **Халдвар дамжих:** Бололцоот бүх зүйлээр

Хонины цэцэг


- Ам хамараар болон эх биенд гарсан яршил



- **Үүсгэгч:** Poxiviridae овгийн Capripox төрөлд хамаарах вирусээр үүсгэгдэнэ
- **Мэдрэмтгий амьтан:** Хонины цэцгийн вирус хоныг, ямааных нь ямаагаа өвчлүүлэх боловч бас 2-ууланг нь өвчлүүлэх үүсгэгч байдаг.
- **Тархалт:** Сүүлийн үед голдуу Ази, Африкийн орнуудад л гарч байна.
- **Манай оронд:** 1977 онд гарсанаас хойш тайван байгаад 2006 онд Сүхбаатар, Хэнтий, Төв аймагт гарсан
- **Эмнэл зүй:** Арьсан дээр нь улаан толбо үүснэ. Энэ дотор эрхтнүүдэд
- **Халдвар дамжих зам:** Хавьтал ба амьсгалын зам болон бусад ялгагдас, шүүрлээр дамжина

Ямааны цэцэг

- Ямаанд илрэх эмгэг хувирлууд



- **Үүсгэгч:** Poxiviridae овгийн Capripox төрөлд хамаарах вирусээр үүсгэгдэнэ
- **Мэдрэмтгий амьтан :** Хонины цэцгийн вирус хоныг, ямааных нь ямаагаа өвчлүүлэх боловч бас 2-ууланг нь өвчлүүлэх үүсгэгч байдаг.
- **Тархалт:** Сүүлийн үед голдуу Ази, Африкийн орнуудад л гарч байна.
- **Манай оронд:** 1967 оноос хойш гараагүй байгаад 2008 онд Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн суманд гарсан
- **Эмнэл зүй:** Арьсан дээр нь улаан толбо үүснэ. Энэ дотор эрхтнүүдэд
- **Халдвар дамжих:** Хавьтал ба амьсгалын замболон бусад ялгагдас, шүүрлээр дамжина

Адууны томуу


- Адууны томуугийн үед илрэх шинж тэмдэгүүд



- **Үүсгэгч:** Myxoviridae овгийн Orthomyxovirus төрлийн Influenza вирусээр үүсгэгддэг.
- **Мэдрэмтгий амьтан:** Битүү туурайтан гэдэг боловч сүүлийн үед бусад хүн малд ч эсрэг бием илэрч байна.
- **Тархалт:** Адууны аж ахуй эрхэлдэг ихэнхи улс оронд тархалттай
- **Манай оронд:** 1974, 1984, 1994, 2007 онуудад дэгдэлт хэлбэрээр гарсан боловч 2011, 2013 онуудад дахин дэгдсэн. Улирлын хэлбэрээр гардаг
- **Эмнэл зүй:** Халуурна, ханиана. Хамраас нь салслага шингэн гоожино гэх мэт
- **Халдвар дамжих:** Агаар дуслын болон хавьталаар


Гахайн сонгомол мялзан

- ГСТӨ-ний үед маш хүчтэй халуурна. Бөөрөнд цус харвана
- **Үүсгэгч:** Flaviviridae овгийн Flavivirusийн төрөл үүсгэдэг
- **Мэдрэмтгий амьтан:** Тэжээвэр болон зэрлэг гахай
- **Тархалт:** Ази болон Карибын арлууд, өмнөд болон төв Америкт тархсан байдаг 2001 оноос Европын нилээд оронд гарсан
- **Манай оронд:** 1982 онд Улаанбаатар хотын гахайн заводод гарч бүгдийг нь устгаж зогссон. 2007 онд мөн хотын хэд хэдэн аж ахуйд гарч устгаж зогсоосон
- **Эмнэл зүй:** Хурц, цочмог, архаг гэх мэт хэд хэдэн хэлбэрээр гарнав шинж тэмдэг нь харидцан адилгүй
- **Халдвар дамжих:** Өвчилсөн гахайн бүх л ялгагдсаар халвар дамжина



Сүүлийн үед давтамж нь ойртож буй өвчнүүд

- Галзуугийн мөчлөгө
- **Галзуу:** Аймгуудын мал эмнэлгийн лаборатори болон УМЭАЦТЛ-т шинжилсэн дүнгээр 2001-2010 онд бүх аймагт мал, амьтны галзуу оношлогдсон байна. Тухайлбал, төв лабораторит 2001-2008 онд галзуугийн шинжилгээнд жилд дунджаар 44 дээж ирж 71,5% нь эерэг гарч байсан бол зөвхөн 2009 онд 50 дээж ирж, 90%-нь, 2010 онд 83 дээж ирж 93,9 %-д нь галзуугийн вирус илэрсэн байна.
- Энэ дээгдэлтэнд үнэг, чоно голлох үүрэгтэй байгаагаас гадна үхэр 47,49, нохой 21,8 9-иар нэрвэгдэж байна.



Боомын идэвхжил



- Сүүлийн жилүүдэд боом өвчний дэгдэлт маш эрчимжиж байна. Тухайлбал, манайд жилд дунджаар 38-41 мал боомоор өвчилдөг байсан бол 2000-2002, 2004 онд нэмэгдэж 49-95 болсон. Харин 2003 ба 2005 онд эрс буурч 0-4, 2006-2012 онд дундаж хэмжээнд буюу 42-48 тохиолдол бүртгэгдсэн боловч голомтын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.
- Үүнээс гадна боомын хүний өвчлөл сүүлийн жилүүдэд нилээд нэмэгдэх хандлагатай байгаа нь санаа зовох асуудлын нэг болж байна.

Хонь, ямааны сохор догол өвчин



Proper teat dipping, using separate towels for cows, dry bedding, and other basic hygiene measures, procedures we've known since the 1950s, are the best prevention against contagious mastitis.

- 1990 оноос өмнө Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгорын говийн бүсээр тархалттай байсан энэхүү өвчин одоо Дорноговь аймгийн Сайхандулаан, Хэнтий аймгийн Дархан сумын нутаг хүртэл буюу зүүн уртрагийн 105 градуст тархалттай байсан өвчин 109 градуст ирсэн нь цаашид зүүн аймгуудад тархаж болзошгүй болсоныг харуулж байна.
- Харин манай хангай бүс буюу Сэлэнгэ, Булган, Архангай, Хөвсгөл аймгуудад явуулсан тандалтаар эерэг урвал илрээгүй нь энэ бүс уг өвчнөөр тайван байгааг харуулж байгаа боловч шилжилт нүүдлийг цаашид хянаж байхгүй бол эрсдэлтэй байна.

Устсаныг баталгаажуулсан ба баталгаажуулахаар зэхэж буй өвчнүүд

- Сертификат



- Үхрийн мялзан
- Үхрийн цээж
- Малын шүлхий
- Ямааны гогдрон
- **Хонь, ямааны цэцэг**

АНХААРАЛ ТАЬСАНД БАЯЛАЛАА